

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Лутын Санжхүү	Дугаар	1034
Оршин суугаа аймаг	Улаанбаатар хот	Оршин суугаа сум	Сүхбаатар дүүрэг
Төрсөн газар	Завхан аймгийн Шилүүстэй сум	Төрсөн он	1915
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Нарбанчэн хутагтын хийд	Сүм хийдийн дугаар	ГАТШ 116
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 11-р сарын 13	Ярилцлага авсан хүн	Ч. Хулан



Говь- Алтай аймгийн Тайшир сумын Нарбанчэн хутагтын хүрээ

Урд хүрээ, хойд хүрээ гэж хоёр байсан. Хойд хүрээ Цогчэн дугантай, урдаа нэг, хоёр талдаа нэг, нэг хойноо өндөр сүмтэй нийлээд 5 дугантай байсан. Урд хүрээнд хоёр давхар байшинтай Ногоон лаврин гэж ярьдаг байсан юм. Гэгээн сан урдаа тамгын газрын байшинтай байсан.

Нарбанчэн хутагтын хийдийг, хоёр хутагтыг Баруун аймгууд Говь-Алтай тэр чигээрээ, Баянхонгорын Баянбулаг, Хүрээмарал, Завханы урд талын сумд Шилүүстэй, Цагаанхайрхан, Цагаанчулуут, Отгон сумынхан тэр чигээрээ шүтдэг байсан юм. Суудаг байсан лам нар нь Хошууч бэйсийнхэн л голчлон суудаг байсан.

Нарбанчэн хутагтын хийд 4 жастай байсан. Дончийн жас, Багшийн сан, Гэгээн сан, Дүйнхорын жас гэж байсан. Нүгнээн жас гэж бас байсан. Дончийн жас, Дүйнхорын жас хоёрыг Багшийн (Дилав хутагт) хөрөнгөөр барьсан. Дончийн жас, Багшийн сан, Дүйнхорын жас их малтай. Гэгээн сан тийм олон их малтай байгаагүй.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Жасын малыг хариулдаг тусгай айлууд байсан. Манайх нэг сангийнх нь хонийг хариулдаг байсан юм. Их олон. Гэхдээ 1000-аас наана. Ер нэг айлд 500, 600-аас илүү мал өгдөггүй байсан байх. Нэг хурга үхсэн ч арьсыг нь сандаа аваачиж өгнө. Тийм үнэнч, шударга байсан юм. Дилав багш өөрөө их өглөгч хүн. Хүмүүс ч дориухан л юм байвал багшид аваачаад өргөчихдөг байсан. Манай нутгийн 5, 6, 7, 8-р багийн айлууд бол Багшийн сангийн малыг хариулдаг айлууд байсан юм. Тэр үед Монгол улс 8 сая малтай байсан гэж хэлдэг. Энэ бол нийт тоо биш. Сан жасын малын тоо л болов уу.

Багшийн сан чинь том шавар дугантай байсан. Одоо ч буурь нь үлдсэн байгаа. Тэр гэр дотор олон амтай том шавар зуух байсан. Манз чанадаг том том тогоо байдаг байсан. Шар тосоор зуураад шар тосонд хайрсан домын хавсай гэж том хавсай хийдэг байсан. Мах шөл их байхгүй. Дандаа цагаан идээ байсан юм. Элбэг дэлбэг ч гэж жигтэйхэн. Багшийн сан шиг юм гэж хүртэл хэлдэг байлаа.

Хүрээний урдуур 10 баяд гэж борчууд байдаг байсан. Арван баяд гэж тэр хоёр санг бараадсан ядуу улсууд байсан юм.

Довдон гэж манай хадам аав Багшийн сангийн нярав байсан юм.

Манай нутагт Өргөн Ширэгийн хүрээ гэж мөн байсан. Цам энэ тэр байхгүй. 10-аад ламтай. Нэг дугантай. Байнгын хуралтай байсан юм гэнэ лээ.